



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/250

Арвайхээр

Тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах,
хүчингүй болгох, нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.5, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.18, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн “Журам батлах тухай” 298 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 2.6.2, 6.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, тусгай зөвшөөрөл олгох ажлын албаны 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрөл шинээр олгох нэр бүхий 5 аж ахуйн нэгжийн нэрийг 1 дүгээр, тусгай зөвшөөрөл сунгах нэр бүхий 1 аж ахуйн нэгжийн нэрийг 2 дугаар, гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах нэр бүхий 1 аж ахуйн нэгжийн нэрийг 3 дугаар, хүчингүй болгох нэр бүхий 2 аж ахуйн нэгжийн нэрийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон, сунгасан, хүчингүй болгосон, нэмэлт өөрчлөлт оруулсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга, аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга (Д.Шивааннүрдэв), Мэргэжлийн хяналтын газрын дарга (С.Дуламсүрэн), Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандаа Б.Мөнх-Эрдэнэ) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0537

Аймгийн Засаг даргын 2022 оны
05 дугаар сарын 19-ны өдрийн
..... дугаар захирамжийн
..... дүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ, ОЛГОХ ХУГАЦАА

д/д	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Тусгай зөвшөөрөл олгох хэлбэр	Олгох хугацаа
1.	“Сидар Мед” хувийн эмнэлэг Сидар медикал ХХК-ийн (РД: 3569055)	Дотор, мэдрэл, Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ үзүүлэх (60 ортой)	Арвайхээр сум 13 дугаар баг	Шинээр олгох	3 жил
2.	“Асури арвай” хувийн эмийн сан Асури арвай фарм ХХК-ийн (РД: 3569209)	Эмийн сангийн үйлчилгээ	Арвайхээр сум 5 дугаар баг	Шинээр олгох	3 жил
3.	Мөнгөн увидас хувийн эмийн сан Энхийн мөнгөн увидас ХХК-ийн (РД: 6811574)	Эмийн сангийн үйлчилгээ	Арвайхээр сум 13 дугаар баг	Шинээр олгох	3 жил
4.	“Арвайн ундарга” хувийн эмийн сан Арвайн Ундрах булаг ХХК-ийн (РД: 3567699)	Эмийн сангийн үйлчилгээ	Арвайхээр сум 13 дугаар баг	Шинээр олгох	3 жил
5.	“Хүрэмт” хувийн эмийн сан Хүрэмт халуун рашаан ХХК-ийн (РД: 5830311)	Эмийн сангийн үйлчилгээ	Тарагт сум 3 дугаар баг	Шинээр олгох	3 жил

Аймгийн Засаг даргын 2022 оны
05 дугаар сарын 19-ны өдрийн
11259 дугаар захирамжийн
00000 дугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ, ОЛГОХ ХУГАЦАА

д/д	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Тусгай зөвшөөрөл олгох хэлбэр	Олгох хугацаа
1	"Сайн шим" хувийн эмийн сан Сайн шим ХХК-ийн (РД: 6243576)	Эмийн сангийн үйлчилгээ	Богд сум 7 дугаар баг	Сунгах	5 жил

-оОо-

Аймгийн Засаг даргын 2022 оны
 05 дугаар сарын 19-ны өдрийн
 А/250 дугаар захирамжийн
 3 дугаар хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ
 ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БАЙГУУЛЛАГА**

д/д	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Нэмэлт өөрчлөлтийн агуулга
1	"Хайрхандулаан" хувийн эмийн сан Ганга идэр ХХК-ийн (РД:3556891)	Эмийн сангийн үйлчилгээ	Хайрхандулаан сум 6 дугаар баг	Ганга идэр ХХК-ийн хувийн хэргийн дугаар 1011121369 болж өөрчлөгдсөн тул аймгийн Засаг даргын 2019 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А/510 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар олгосон тусгай зөвшөөрлийн 14 дүгээрт бичигдсэн "Хайрхандулаан" хувийн эмийн сангийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд хувийн хэргийн дугаарыг 1011121369 болгож өөрчлөлт оруулах (тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан)

Аймгийн Засаг даргын 2022 оны
 05 дугаар сарын 19-ны өдрийн
 дугаар захирамжийн
 дүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ
 ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ БАЙГУУЛЛАГА

д/д	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл
1	“Болор шүүдэргэнэ” хувийн эмийн сан Болор шүүдэргэнэ ХХК-ийн (РД: 35630222)	Эмийн сангийн үйлчилгээ	Арвайхээр сум 13 дугаар баг	Хангайн болор шүүдэргэнэ (РД: 3563022) ХХК нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг болсон тул аймгийн Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн А/307 дугаар захирамжаар олгосон тусгай зөвшөөрлийн 5 дугаарт бичигдсэн “Болор шүүдэргэнэ” хувийн эмийн сангийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох (тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан)
2	“Арвайн ундарга” хувийн эмийн сан Дөлгөөн нар очир ХХК-ийн (РД: 3552209)	Эмийн сангийн үйлчилгээ	Арвайхээр сум 13 дугаар баг	Дөлгөөн нар очир (РД: 3552209) ХХК нь үйл ажиллагаа эрхлэхгүй болсон тул аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/468 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар олгосон тусгай зөвшөөрлийн 2 дугаарт бичигдсэн “Арвайн ундарга” хувийн эмийн сангийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох (тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан)